

ШУТИС-ИЙН ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТЕХНОЛОГИЙН ДЭЭД СУРГУУЛИЙН ХАРЬЯА МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН НОМЫН САНГИЙН ТАНИЛЦУУЛГА

Тус сургуулийн номын сан 1963 онд сургууль байгуулагдсан цагаас эхлэн өдгөө 60 дахь жилтэйгээ золгож байна. Улс эх орны бүтээн байгуулалтын салбарт мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх их уурхай болсон манай сургуулийн сургалт хүмүүжлийн ажлын цар хүрээ өргөжин тэлж суралцагчдын тоо нь жилээс жилд өсөн нэмэгдэж ирсэн түүхтэй.



Энэхүү түүхэн хөгжлийн явцад тус номын сан нь сургалтын явц түүний хөгжлийн алхаа, багш,



суралцагчдынхаа эрэлт хэрэгцээг гүйцэт ханган биелүүлж, соён гэгээрүүлэх их үүргээ нэр төртэйгээр гүйцэтгэн уншлагын заалны суудлынхаа тоог нэмэгдүүлэн номынхоо фондыг арвтжуулахын зэрэгцээ тухайн мэргэжлийн хэрэгцээт ном, сурах бичиг, лавлах материалуудыг холбогдох салбарын яам, мэргэжлийн институт, эрдэм шинжилгээний байгууллагууд, төсөл хөтөлбөрүүдээс байнгын холбоотойгоор татан авалт нийлүүлэлт хийж баяжуулсаар ирсэн юм.

Тус сургуулийн хөгжлийн явцад: 1963 онд “Залуу малчны сургууль”, 1971 онд “Хөдөө Аж Ахуйн Техник Мэргэжлийн сургууль”, 1991 онд “Мэргэжлийн Сургалт Үйлдвэрлэлийн Төв”, 2014 онд “Өмнөговь аймгийн Политехник Коллеж” болон өргөжиж түүнийг даган номын фонд нь улам өргөжин арвижсан билээ.

Номын сан нь фондын 2 өрөө, уншлагын 1 танхимтай, оюутны дотуур байранд салбар фонд, уншлагын танхимтай, нэг номын санчтайгаар үйл ажиллагаа явуулж байна. Номын сан нь 22988 гаруй мянган номын фондтой, багш, ажилтан, оюутнууддаа үйлчилж үйл ажиллагаа нь тогтмолжин сургуулийнхаа сургалт хүмүүжлийн үйл ажиллагааны чухал салшгүй хэсэг нь болж иржээ.

Тус сургуулийн номын санчид: Г.Сэмнэд, Сугир, Бөнтөн, Цэенпил, И.Одгэрэл, Ууганбаяр, Насантунгалаг, Б.Энхцэцэг нарын дадалга туршлага бүхий номын санчид ажиллаж ирсэн юм.

Номын фондын баяжилтыг оновчтой болгохын тулд сургуулийн удирдлага, мэргэжлийн тэнхимүүд, номын санч нарын төлөөлөл бүхий хүмүүсийн саналаар шийдвэрлэдэг болж ирсэн юм.

Номын сангийн үйлчилгээг орчин үеийн жишигт хүргэхийн тулд 2022 оноос номын сангийн irc.lib4u.net програмд 1602нэр төрлийн 11540ш номын нэрсийг бүртгэж оруулж байна. Уншлагад чөлөөт сонголтоор уран зохиол, мэргэжлийн сурах бичиг, англи хэлний ном сурах бичиг зэрэг номоор үйлчилж байна.

Сургуулийн номын сан сурч боловсрохын их аянд аялаж яваа багш сурагчиддаа соён гэгээрүүлэх их үйлст хувь нэмрээ нэр төртэйгээр оруулсаар ирлээ.

